

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/01/НА-СТА-ТӨА

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА  
ШТН ТӨААТҮГ-ЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasurenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлангай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

## **АГУУЛГА**

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан .....
- 4.1 Ерөнхий зүйл .....
- 4.2 Материаллаг байдал .....
- 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### **Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХЗДХЯ	Зам Тээвэр Хөгжлийн Яам
ЗТХТ	Зам тээвэр хөгжлийн төв
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.15 № 01/2024

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу ШШГЕГ-ын харьяа Төв аймгийн Баян сум дахь “ШТН” ТӨААТҮГ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“ШТН” ТӨААТҮГ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

“ШТН” ТӨААТҮГ нь үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг төлөвлөгөөний дагуу нэмэгдүүлж чадаагүй бөгөөд Стандарт бридж капитал ХХК-д борлуулсан бүтээгдэхүүнээр бартер хийн 6,600.0 төгрөгийн тоног төхөөрөмжийг 2023 оны 05 сард хүлээн авсан боловч хөрөнгийг орлогод авах зөвшөөрөл нь ТӨБЗГ-аас ирээгүй байна.

2023 оны 10 дугаар сарын 18-ний өдөр уул уурхайн “Лаймстоун минералс” ХХК-тай гэрээ байгуулж, ажлын төлөвлөгөөг /ТЭЗҮ/ шинээр боловсруулан Ашигт малтмал, газрын тосны ерөнхий газрын дэргэдэх Эрдэс баялагын мэргэжлийн зөвлөлийн хуралаар 2024 оны 03 дугаар сарын 22-ний өдөр хэлэлцүүлэхээр тов зарлагдсан байна.

**Аудитын гол асуудал**

“ШТН” ТӨААТҮГ-т үйлдвэрлэл уурхайн ажлын төлөвлөгөө /ТЭЗҮ/ хийгдээгүй, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, хуучирч актлагдсан, хөрөнгө санхүү, боловсон хүчин байхгүйгээс шалтгаалан уурхайд тэсэлгээ хөрс хуулалтын ажил хийгдээгүй тул орлогын төлөвлөгөө 75,8 хувиар тасарсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон

хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	863,358,219.7	777,270,197.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	240,696.5	10,138,943.9
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	240,696.5	10,138,943.9
3121	Төгрөг	240,696.5	10,138,943.9
31213	Арилжааны банк дахь харилцах	240,696.5	10,138,943.9
33	АВЛАГА	100,050,837.0	21,794,656.0
33401	Дансны авлага /ТӨҮГ/	98,910,837.0	21,794,656.0
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	1,140,000.0	0.0
34	УРЬДЧИЛГАА	70,740,000.0	70,740,000.0
34600	Урьдчилж гарсан зардал	70,740,000.0	70,740,000.0
35	БАРАА МАТЕРИАЛ	692,326,686.2	674,596,598.0
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	633,892,260.4	495,660,346.6
35300	Бэлэн бүтээгдэхүүн	12,846,849.9	140,428,205.6
354	Хангамжийн материал	45,587,576.0	38,508,045.8
35410	Бичиг хэргийн материал	1,273,411.8	978,318.2
35430	Сэлбэг хэрэгсэл	686,181.8	1,008,590.9
35460	Хүнсний материал	526,932.9	0.0
35470	Бусад хангамжийн материал	43,101,049.5	36,521,136.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,372,091,020.7	1,436,708,459.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,372,091,020.7	1,436,708,459.6
392	Биет хөрөнгө	679,687,020.7	744,304,459.6
39201	Барилга, байгууламж, орон сууц	218,999,751.4	218,999,751.4
39202	Хуримтлагдсан элэгдэл	-86,384,101.2	-106,978,294.9
39203	Авто-тээврийн хэрэгсэл	405,539,623.0	381,333,333.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-364,203,234.0	-241,839,443.9
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	675,399,945.4	579,322,161.2
39206	Хуримтлагдсан элэгдэл	-174,791,950.1	-99,904,962.8
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,270,048.0	18,077,348.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,540,161.8	-5,102,532.5
39214	Бусад үндсэн хөрөнгө	36,323,000.0	36,323,000.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-36,323,000.0	-36,323,000.0
39216	Дуусаагүй барилга, байгууламж	397,100.0	397,100.0
393	Биет бус хөрөнгө	692,404,000.0	692,404,000.0
39301	Програм хангамж	6,417,692.3	6,417,692.3
39302	Хуримтлагдсан элэгдэл	-6,417,692.3	-6,417,692.3
39303	Бусад биет бус хөрөнгө	692,404,000.0	692,404,000.0

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,235,449,240.4	2,213,978,657.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	180,658,876.6	156,813,686.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	180,658,876.6	156,813,686.0
413	Өглөг	121,176,049.2	90,813,686.0
4136	Бусад өглөг	121,176,049.2	90,813,686.0
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	121,176,049.2	90,813,686.0
414	Урьдчилж орсон орлого	59,482,827.4	66,000,000.0
41440	Бусад урьдчилж орсон орлого	59,482,827.4	66,000,000.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,054,790,363.8	2,057,164,971.5
51	Засгийн газрын хувь оролцоо	2,054,790,363.8	2,057,164,971.5
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,156,313,966.0	1,156,313,966.0
51101	Өмч: - төрийн	1,156,313,966.0	1,156,313,966.0
512	Хуримтлагдсан үр дүн	716,752,386.89	719,126,994.20
51210	Өмнөх үеийн үр дүн	332,030,034.09	736,752,386.55
51220	Тайлант үеийн үр дүн	384,722,352.80	-17,625,392.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	181,724,011.25	181,724,011.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,235,449,240.4	2,213,978,657.5

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

№	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО(цэвэр)	142,835,499.91	217,737,636.38
02	БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ	99,940,708.63	169,051,781.38
03	НИЙТ АШИГ ( алдагдал)	42,894,791.28	48,685,855.00
04	Түрээсийн орлого	0.00	0.00
05	Хүүний орлого	0.00	4,001.01
06	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
07	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
08	Бусад орлого	0.00	282,882,469.76
08.1	ОРЛОГЫН ДҮН	0.00	282,886,470.77
09	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	126,440,533.15	373,311,567.04
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	0.00
12.1	ЗАРДЛЫН ДҮН	126,440,533.15	373,311,567.04
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг ( алдагдал)	480,670,526.60	25,000,000.00
17.1	ОЛЗ,ГАРЗЫН ДҮН	480,670,526.60	25,000,000.00
18	ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ( алдагдал)	397,124,784.73	-16,739,241.27
19	Орлогын татварын зардал	12,402,432.27	886,151.08

20	ТАТВАРЫН ДАРААХ АШИГ (алдагдал)	384,722,352.46	-17,625,392.35
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ ( алдагдал)	384,722,352.46	-17,625,392.35
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	ОРЛОГЫН НИЙТ ДҮН	0.00	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,156,313,966.01	181,724,011.25	337,763,850.50	1,675,801,827.76
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	-5,733,816.41	-5,733,816.41
03	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	384,722,352.46	384,722,352.46
05	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
06	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
07	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
09	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,156,313,966.01	181,724,011.25	716,752,386.55	2,054,790,363.81
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	20,000,000.00	20,000,000.00
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	-17,625,392.35	-17,625,392.35
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
17	2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл	1,156,313,966.01	181,724,011.25	719,126,994.20	2,057,164,971.46

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
0	Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ	0.00	0.00
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
1.1	МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (+)	216,403,200.00	633,248,313.78
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	213,113,200.00	172,195,087.66
1.1.6	Бусад мөнгөн орлого	3,290,000.00	461,053,226.12
1.2	МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (-)	405,672,396.72	543,354,067.35
1.2.1	Ажиллагчдад төлсөн	133,217,437.40	258,167,850.22
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	4,341,978.07	4,575,416.08
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	64,490,372.00	25,948,087.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	25,946,314.74	29,836,706.50
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	64,232,490.00	82,637,730.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	27,304,259.51	41,537,609.55
1.2.9	Бусад мөнгөн зарлага	86,139,545.00	100,650,668.00
1.3	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-189,269,196.72	89,894,246.43
2.1	МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (+)	0.00	4,001.01
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.00	4,001.01
2.3	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	4,001.01
3.1	МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (+)	189,078,204.00	0.00
3.1.4	Бусад	189,078,204.00	0.00
3.2	МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (-)	0.00	80,000,000.00
3.2.5	Бусад	0.00	80,000,000.00
3.3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	189,078,204.00	-80,000,000.00
4	БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-190,992.72	9,898,247.44
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	431,689.19	240,696.47
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	240,696.47	10,138,943.91

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Бүтээгдэхүүний төрөл	Үйлдвэрлэл			Борлуулалт		
	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1 Шохойн чулуу	250,000.0	154,404.0	62%	120,000.0	5,000.0	4%
2 Эрдэс нунтаг	23,100.0	40,128.7	174%	30,000.0	58,084.5	194%
3 Замасканы бэлдэц	355,300.0	75,334.1	21%	418,000.0	82,894.0	20%
4 Шохой	124,300.0	-	0%	180,000.0	-	0%
5 Мозайкан чулуу	158,015.0	45,030.1	28%	30,000.0	5,103.0	17%
6 Хар замаска	92,769.6	16,940.0	18%	134,400.0	25,690.0	19%
7 Цагаан замаска	33,616.0	28,522.8	85%	48,000.0	30,605.1	64%
8 Плита цавуу	16,400.0	19,850.8	121%	23,200.0	30,574.5	132%
<b>НИЙТ ДҮН</b>	<b>1,053,500.6</b>	<b>380,210.5</b>	<b>36.1%</b>	<b>983,600.0</b>	<b>237,951.1</b>	<b>24.2%</b>

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Компани/ТӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

ШТН ТӨААТҮГ нь ШШГЕГ-аас олгосон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажилладаг, хоригдлыг ажлын байраар хангаж төрөл бүрийн шохойн чулуу, шохой, замаска, эрдэс нунтаг болон бусад шохойн чулуун эдлэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд болон ерөнхий газрын харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги, салбар нэгжид нийлүүлэх чиг үүрэг бүхий төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар юм.

#### 3.2 Компани/ТӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

“ШТН” ТӨААТҮГ нь хорих ял эдэлж буй хоригдлыг ажлын байраар хангах, гэм хорын хохирлыг нөхөн төлүүлэх “Эрдэнэт” УБҮ-ыг /тухайн үеийн нэршлээр/ боловсруулсан шохойгоор хангах зорилгоор Хорих 415-р анги ашиглаж ирсэн бөгөөд “Шохой тоосгоны нэгдэл” Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар үүсгэн байгуулагдсан үеэс дангаараа шохойн чулуу, шохой, эрдэс нунтаг, замаскны бэлдэц, мозайкан чулуу боловсруулан үйлдвэрлэж, 2020 оноос БНХАУ-ын технологиор барилгын ажилд хэрэглэх 3 төрлийн хуурай хольцыг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж, үйл ажиллагааг явуулж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ”, Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ”, 16.2-т “Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана” гэж заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд ШТН ТӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

“ШТН” ТӨААТҮГ-ын дотоод хяналтын хариуцсан ажилтан буюу ажлын нэгж байхгүй төлөвлөгөө хуваарийг батлуулаагүй бөгөөд дотоод аудитын нэгж, алба байхгүй байна. “ШТН” ТӨААТҮГ-ын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай

байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ШШГЕГ-ын харьяа “ШТН” ТӨААТҮГ-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

“ШТН” ТӨААТҮГ-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“ШТН” ТӨААТҮГ-ийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,470.6 мянган төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	240.7	10,138.9	9,898.2
Авлага	100,050.8	21,794.7	(78,256.2)
Урьдчилгаа	70,740.0	70,740.0	-
Бараа материал	692,326.7	674,596.6	(17,730.1)
Үндсэн хөрөнгө	1,372,091.0	1,436,708.5	64,617.4
Нийт хөрөнгө	2,235,449.2	2,213,978.7	(21,470.6)
Өр төлбөр	180,658.9	156,813.7	(23,845.2)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,054,790.4	2,057,165.0	2,374.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,235,449.2	2,213,978.7	(21,470.6)

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн дансны үлдэгдэл өмнөх оноос өсөж, авлага, бараа материал, өр төлбөрийн дансны үлдэгдэл өмнөх оны үзүүлэлтээс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- Бараа материал дансны хувьд бэлэн бүтээгдэхүүн 127,581.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, дуусаагүй үйлдвэрлэл 138,231.9 мянган төгрөг, бусад хангамжийн

материал 7,079.5 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

- Үндсэн хөрөнгө данс 2023 онд тавилга эд хогшил 8,807.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, шилжүүлсэн 226,482.0 мянган төгрөгөөр буурсан байна.
- Тайлант онд 2 тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаа үнийг 105,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 10,005.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,057,165.0 мянган төгрөг болж 2,375.0 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

ШТН ТӨААТҮГ нь 100% дотоод орлогоосоо санхүүждэг бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнтэй холбоотой зардал болон удирдлагын зардал гэсэн хөтөлбөр ангилалтай.

2023 онд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний төлөвлөгөө 913,129.6 мянган төгрөг, борлуулалтын төлөвлөгөө нь 979,100.0 мянган төгрөг, удирдлагын зардал 100,000.0 мянган төгрөг байхаар Шүүхийн шийдвэр санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газраас батлагдаж ирсэн байна.

Хүснэгт 2. Төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Бүтээгдэхүүний төрөл	Үйлдвэрлэл			Борлуулалт		
	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1 Шохойн чулуу	250,000.0	154,404.0	62%	120,000.0	5,000.0	4%
2 Эрдэс нунтаг	23,100.0	40,128.7	174%	30,000.0	58,084.5	194%
3 Замасканы бэлдэц	355,300.0	75,334.1	21%	418,000.0	82,894.0	20%
4 Шохой	124,300.0	-	0%	180,000.0	-	0%
5 Мозайкан чулуу	158,015.0	45,030.1	28%	30,000.0	5,103.0	17%
6 Хар замаска	92,769.6	16,940.0	18%	134,400.0	25,690.0	19%
7 Цагаан замаска	33,616.0	28,522.8	85%	48,000.0	30,605.1	64%
8 Плита цавуу	16,400.0	19,850.8	121%	23,200.0	30,574.5	132%
<b>НИЙТ ДҮН</b>	<b>1,053,500.6</b>	<b>380,210.5</b>	<b>36.1%</b>	<b>983,600.0</b>	<b>237,951.1</b>	<b>24.2%</b>

Гүйцэтгэлээр бүтээгдэхүүний борлуулалтаас 237,951.1 мянган төгрөг, төмөр зам, талбай ашиглуулсны төлбөр 247,634.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 567,363.3 мянган төгрөгийн зардал гарган, 17,625.4 мянган төгрөгийн татварын өмнөх алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 237,951.1 мянган төгрөг болж төлөвлөснөөс 748,098.90 мянган төгрөг буюу 75,8 хувиар, үйлдвэрлэлийн төлөвлөгөө 7,190.1 тн-оор буюу 34,2 хувиар тасарсан нь уурхайд уулын ажлын төлөвлөгөө /ТЭЗҮ/ 3 жил огт хийгдээгүй, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, хуучирч актлагдсан хөрөнгө санхүү, боловсон хүчин байхгүйн улмаас уурхайд тэсэлгээ хөрс хуулалтын ажил хийгдээгүйтэй холбоотой байна.

Тайлант онд 21.0 мянган тн 8 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 983,600.0 мянган төгрөгийн борлуулалт хийж, 100,000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр 10.4 мянган тн 7 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 380,210.5 /НӨАТ орсон дүн/ мянган төгрөгийн борлуулалт хийж, үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлт 36.1 хувь, борлуулалтын төлөвлөгөө 24,2 хувьтай байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэлийн 169,051.8 мянган төгрөг буюу 31,1 хувь нь борлуулсан бүтээгдэхүүний өөрийн өртөг,

373,311.6 мянган төгрөг буюу 68,9 хувь удирдлагын зардал эзэлж байна. ШШГЕГ-т тайлант онд ногдол ашгийн 90,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлжээ.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу ШШГЕГ-ын харьяа “ШТН” ТӨААТҮГ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх “ШТН” ТӨААТҮГ түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Адъяасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

“ШТН” ТӨААТҮГ-ийн 2023 оны санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/11 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 405,481.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 6,082.2 мянган төгрөгөөр тогтоосны 75 хувиар гүйцэтгэлийн материаллаг байдлыг 4,561.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

ШТН ТӨААТҮГ нь тайлант онд төсвийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 182 мэдээлэл байршуулахаас 177 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 5 мэдээлэл хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 154,390.0 мянган төгрөгийн 16 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 521,438.8 мянган төгрөгийн 37 гүйлгээ, тендэрт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэлтэй холбоотой 269,990.0 мянган төгрөгийн 8 мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлтэй холбоотой 166,880.0 мянган төгрөгийн 12 мэдээлэл хугацаанд нь байршуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

“ШТН” ТӨААТҮГ-ийн 2023 оны эхний хагас жилийн баримтад завсрын аудит хийж, аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

“ШТН” ТӨААТҮГ 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмжийг өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн “ШТН” ТӨААТҮГ-ийн захирлын 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 01/147 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	412,717.5	2	412,717.5	100
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>412,717.5</b>	<b>2</b>	<b>412,717.5</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

“ШТН” ТӨААТҮГ-ын санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

### Залруулсан алдаа

Аудитаар нийт 157,343.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 157,343.6 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн 2023 оны 7 сарын элэгдлийн зардал болох 3,706.1 мянган төгрөгийн зардлыг байгуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Байгууллагаас гаргасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 2,270.0 мянган төгрөгийн 6 шийдвэр, Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын гүйлгээ 5 ширхэг 76,007.1 мянган төгрөг, Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын гүйлгээ 9 ширхэг 75,360.4 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ШТН ТӨААТҮГ-ын авто тээврийн хэрэгсэлд бүртгэлтэй 1295ТӨН улсын дугаарт цэнхэр дэвсгэртэй дугаар аваагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

дугаар хэрэглэнэ” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлагналтай холбоотой алдаа	2	157,343.6	2	157,343.6			2	157,343.6				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>157,343.6</b>	<b>2</b>	<b>157,343.6</b>			<b>2</b>	<b>157,343.6</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
			Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төв аймаг дахь ШТН ТӨААТҮГ-ын авто тээврийн хэрэгсэлд бүртгэлтэй 1295ТӨН улсын дугаарт цэнхэр дэвсгэртэй дугаар аваагүй байна	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>					<b>1</b>	<b>-</b>